



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

ЦАГДААГИЙН ЕРӨНХНИЙ ГАЗАР

Самбуугийн гудамж 18, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Улаанбаатар хот, 14201, Утас: 7019-1087 Факс: 7019-1087.

Цахим шуудан: info@police.gov.mn

Цахим хаяг: www.police.gov.mn

2022.12.30 3/479

танай _____ -ны № _____


ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
О.ЦОЛМОН ТАНАА

Цагдаа, дотоодын цэргийн анги,
байгууллагын Шилэн дансны тухай хуулийн
хэрэгжилтийн тайланг 2022 оны жилийн эцсийн
байдлаар гаргаж, хүргүүлэв.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт ¹⁵ хуудастай.

ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА П.ОРОСТОГОО



1522 07 6966

**ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН АНГИ, БАЙГУУЛЛАГЫН
ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

/2022 оны жилийн эцсийн байдлаар/

Шилэн дансны тухай хуулийн дагуу www.shilendans.gov.mn шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цагдаа, дотоодын цэргийн 54 анги, байгууллагаас 2022 онд байршуулсан мэдээллийн статистик үзүүлэлт, хэрэгжилтийн байдал, тухайн хуулийн хэрэгжилтийг хангах талаар Цагдаагийн ерөнхий газраас авч хэрэгжүүлсэн ажлыг нэгтгэн танилцуулж байна. Үүнд:

**Нэг. Мэдээлэл байршуулж байгаа байгууллагын
статистик үзүүлэлт:**

Шилэн дансны тухай хуулийн 3.1 дүгээр зүйлд заасны дагуу 2022 оны байдлаар цагдаа, дотоодын цэргийн 54 анги, байгууллагын шилэн дансны мэдээлэл хариуцсан 59 албан тушаалтнаас нэгдсэн системд 20 төрлийн мэдээллийг байршуулж, олон нийтэд тайлагнасан байна. Хүснэгт 1

Д/д	Байгууллагын төрөл	Байгууллагын тоо	Мэдээлэл оруулах эрхтэй хэрэглэгчийн тоо	Хуулийн үйлчлэл
1	Цагдаагийн ерөнхий газар /төсвийн байгууллага/	54	59	3.1.1
	Нийт	54	59	

**Хоёр. Төсвийн ерөнхийлөн захирагчийн Шилэн дансны
тухай хуулийн хэрэгжилтийн байдал:**

Мэдээлэл байршуулах давтамжийн хугацаагаар тооцож үзэхэд 2022 онд Цагдаа, дотоодын цэргийн 54 байгууллага 216 улирлын тайлан илгээж, тайлан илгээлт 100 хувь, шилэн дансны нэгдсэн цахим системд 8694 мэдээллийг мэдээлэхээс хугацаа болоогүй 108 мэдээлэл, энэ хугацаанд мэдээлэх 8586 мэдээллийг 100 хувь мэдээлсэн. Хүснэгт 2

Д/д	Мэдээллийн төрөл	Нийт мэдээлэх	Хугацаан даа	Хугацаа хоцорсон	Мэдээлэх хугацаа болоогүй	Хэрэгжилт
1	Тухай бүр мэдээлэх	5616	5559	57		99.0
2	Тогтоосон хугацаанд мэдээлэх	1350	1336	14	108	99.0
3	Хяналтын багцаар мэдээлэх	1620	1602	18		99.0
	Нийт	8586	8497	89	108	99.0

Шилэн дансанд мэдээлэл байршуулсан хугацааны хэрэгжилтийг дүгнэж үзвэл **99.0** хувьтай байна.

Энэ оны жилийн эцсийн байдлаар цагдаа, дотоодын цэргийн 54 анги, байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл оруулсан, улирлын тайлан илгээлтийн хэрэгжилтийг хүснэгтээр нэгтгэн харуулав.

Д/д	Яам, агентлаг, байгууллагууд	Системд бүртгэлтэй байгууллагын тоо	Тайлан илгээх давтамжийн тоо	Тайлан илгээсэн давтамжийн тоо	Тайлан илгээсэн хувь	Тухайн хугацаанд мэдээлэх давтамжийн тоо	Тухайн хугацаанд мэдээлсэн давтамжийн тоо	Хугацаа болоогүй мэдээлэл	Мэдээлсэн хувь	Нийт дундаж хувь
1	Цагдаагийн ерөнхий газар	54	216	216	100	8694	8586	108	100	100

Гурав. Байршуулсан мэдээллийн статистик үзүүлэлт:

Цагдаагийн ерөнхий газар Шилэн дансны тухай хуульд заасны дагуу төсөв гүйцэтгэлийн 9, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 5, бусад 6 төрлийн мэдээллийг жил, хагас жил, сар бүр, тухай бүр, 7 хоног тутам гэсэн хугацааны давтамжтайгаар байршуулж байна.

Мэдээлэл байршуулах давтамжийн хугацаагаар тооцож үзэхэд 2022 оны жилийн эцсийн байдлаар нэг нэгж 20 төрлийн мэдээг давтамжтайгаар 159 удаа, системийн хэмжээнд нийт 8586 мэдээллийг байршуулахаас хугацаанд нь 8497, хугацаа хоцроон байршуулсан 89 мэдээ байна.

Энэ оны жилийн эцсийн байдлаар цагдаа, дотоодын цэргийн 54 анги, байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг хүснэгтээр нэгтгэн харуулав.

Хүснэгт 4

1. Мэдээллийг төрөл, байршуулсан хугацаагаар нь ангилсан байдал:

№	Байршуулах мэдээллийн төрөл	Байршуулах мэдээ	Мэдээлсэн	Хугацаандаа	Хоцор сон	Байршуулаагүй	Хугацаа болоогүй	Хэрэгжилт
1	2	3	4	5	6	7	8	9
1.Төсөв гүйцэтгэл								
1	Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)	54	54	54	-	-	-	100
2	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр,Хагас жилээр,Улирал бүр,Сар бүр)	972	972	963	9	-	-	99.1
3	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)	702	702	693	9	-	-	98.7
4	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (Бүтэн жилээр,Хагас жилээр)	108	108	108	-	-	-	100
5	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр,Хагас жилээр)	108	108	108	-	-	-	100
6	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)	702	702	695	7	-	-	98.7

7	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)	54	-	-	-	-	54	-
8	Санхүүгийн тайлан (Хагас, бүтэн жилээр)	108	54	53	1	-	54	98.1
9	Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)	54	54	52	2	-		96.3
	Дүн	2862	2754	2726	28	-	108	98.9
2. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт								
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Бүтэн жилээр)	54	54	52	2	-		96.3
2	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр)	756	756	745	11	-	-	98.5
3	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр)	702	702	696	6	-	-	99.1
4	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр)	702	702	693	9	-	-	98.7
5	Худалдан авах ажиллагааны тайлан (Бүтэн жил)	54	54	-	-	-	-	100
	Дүн	2268	2268	2240	28		-	98.5
3. Бусад								
1	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр)	702	702	695	7	-	-	99.0
2	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр)	702	702	695	7	-	-	99.0
3	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (Бүтэн жилээр)	54	54	54	-	-	-	100
4	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (Тухай бүр)	702	702	696	6	-	-	99.1
5	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (Сар бүр)	702	702	694	8	-	-	98.9
6	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн (Тухай бүр)	702	702	696	5	-	-	99.4
	Дүн	3564	3564	3531	33		-	99.1

	НИЙТ ДҮН	8694	8586	8497	89	-	108	99.0
--	----------	------	------	------	----	---	-----	------

2. Мэдээллийг нэгж, байршуулсан хугацаагаар нь харуулсан байдал:

№	Нэгжийн нэр	Байршуулах мэдээ	Байршуулсан мэдээ		Хувь
			Хугацаандаа	Хоцорсон	
1	Санхүү, аж ахуйн алба	159	154	5	96.9
2	Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газар	159	159	0	100.0
3	Эрүүгийн цагдаагийн алба	159	159	0	100.0
4	Тээврийн цагдаагийн алба	159	147	12	92.5
5	Мөрдөн байцаах алба	159	145	14	91.2
6	Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба	159	159	0	100.0
7	Экологийн цагдаагийн алба	159	159	0	100.0
8	Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба	159	159	0	100.0
9	Тээврийн цагдаагийн албаны Төмөр зам дахь цагдаагийн газар	159	159	0	100.0
10	Цагдаагийн ерөнхий газрын Автобааз	159	159	0	100.0
11	Цагдаагийн ерөнхий газрын Гэрээт хамгаалалт	159	153	6	96.2
12	Цагдаа дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв	159	158	1	99.4
13	Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төв	159	157	2	98.7
14	Цагдаагийн ерөнхий газрын Хүч спорт хороо	159	159	0	100.0
15	Цагдаагийн ерөнхий газрын цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын "Сүүж-Уул" сэргээн засах сувилал	159	159	0	100.0
16	Цагдаагийн ерөнхий газрын Сүлд чуулга	159	148	11	93.1
17	Дотоодын цэргийн 05 дугаар анги	159	159	0	100.0
18	Дотоодын цэргийн 805 дугаар анги	159	156	3	98.1
19	Архангай аймаг дахь Цагдаагийн газар	159	159	0	100.0
20	Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газар	159	159	0	100.0
21	Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар	159	159	0	100.0
22	Булган аймаг дахь Цагдаагийн газар	159	159	0	100.0
23	Говь-Алтай аймаг дахь Цагдаагийн газар	159	159	0	100.0
24	Дархан-Уул аймаг дахь Цагдаагийн газар	159	148	11	93.1
25	Дорноговь аймаг дахь Цагдаагийн газар	159	159	0	100.0
26	Дорнод аймаг дахь Цагдаагийн газар	159	159	0	100.0
27	Дундговь аймаг дахь Цагдаагийн газар	159	159	0	100.0
28	Завхан аймаг дахь Цагдаагийн газар	159	159	0	100.0
29	Орхон аймаг дахь Цагдаагийн газар	159	159	0	100.0
30	Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газар	159	159	0	100.0

31	Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газар	159	157	2	98.7
32	Сүхбаатар аймаг дахь Цагдаагийн газар	159	156	3	98.1
33	Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газар	159	159	0	100.0
34	Төв аймаг дахь Цагдаагийн газар	159	159	0	100.0
35	Увс аймаг дахь Цагдаагийн газар	159	159	0	100.0
36	Ховд аймаг дахь Цагдаагийн газар	159	159	0	100.0
37	Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газар	159	148	11	93.1
38	Хэнтий аймаг дахь Цагдаагийн газар	159	159	0	100.0
39	Говьсүмбэр аймаг дахь Цагдаагийн хэлтэс	159	159	0	100.0
40	Дорноговь аймаг Замын үүд дэх сум дундын цагдаагийн хэлтэс	159	156	3	98.1
41	Сэлэнгэ аймаг дахь Мандал сумын цагдаагийн хэлтэс	159	159	0	100.0
42	Сэлэнгэ аймаг дахь Сайхан сумын цагдаагийн хэлтэс	159	159	0	100.0
43	Өвөрхангай аймаг дахь Хархорин сум дундын цагдаагийн хэлтэс	159	159	0	100.0
44	Нийслэлийн цагдаагийн удирдах газар	159	158	1	99.4
45	Баянгол дүүрэг дэх цагдаагийн газар	159	159	0	100.0
46	Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газар	159	159	0	100.0
47	Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн хэлтэс	159	158	1	99.4
48	Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн хэлтэс	159	159	0	100.0
49	Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн хэлтэс	159	158	1	99.4
50	Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн газар	159	159	0	100.0
51	Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтэс	159	159	0	100.0
52	Багахангай дүүрэг дэх цагдаагийн хэлтэс	159	159	0	100.0
53	Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэс	159	157	2	98.7
54	Дотоодын цэргийн штаб	159	159	0	100.0
НИЙТ ДҮН		8586	8497	89	99.0

Дөрөв. Цахим хуудасны мэдээлэл байршуулалтад хяналт тавьсан байдал:

Цагдаагийн ерөнхий газраас Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.5, “Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах /Код 135/ журам”-ын 135.7.4 дэх хэсэгт заасны дагуу цагдаа, дотоодын цэргийн 54 анги, байгууллагын төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Тухайлбал:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, түүнтэй холбоотой гарч буй алдаа, зөрчлийг арилгах, сайжруулах зорилгоор “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2021, 2022 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.14, 2.4-т заасны дагуу энэ оны 1 дүгээр сард 2021 оны жилийн эцсийн болон 2022 оны эхний хагас жилийн байдлаар дотоод аудит хийж, тайлангаас үндэслэн нийт 10-н төрлийн үүрэг, зөвлөмжийг цагдаа, дотоодын цэргийн 54 анги, байгууллагын удирдлагад хүргүүлэн биелэлтэд хяналт тавьж ажилласан;

2. Цагдаа, дотоодын цэргийн 54 анги, байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2021 оны жилийн эцэс, 2022 оны 1-3 дугаар улирлын тайлан, мэдээг нэгтгэн, хуулийн хэрэгжилтийг хангах талаар цагдаагийн байгууллагаас хийсэн ажлын

тайланг, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 3/12, 04 дүгээр сарын 13-ны өдрийн 3/157, 10 дугаар сарын 17-ны өдрийн 3/364, Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 6/5933 дугаар албан бичгээр болон цахимаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахимаар болон бичгээр хуулийн хугацаанд хүргэсэн;

3. Үндэсний аудитын газраас Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхдээ байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас аудитад хамааралтай (Санхүү, нягтлан бодох бүртгэл, Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн дотоод аудитын тайлан) хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд “Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт” хэсэгт “Дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна” гэж тайлагнасан байна.

Үндэсний аудитын газар болон орон нутаг дахь аудитын газарт цагдаа, дотоодын цэргийн 54 /нууцын зэрэглэлтэй 1 байгууллага/ байгууллагын 2021 оны санхүүгийн тайланг хүргүүлснээс 37 байгууллагад дүгнэлт гаргаж, 17 байгууллага түүвэрлэгдэн шалгагдаж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 12 зөвлөмж, 2 албан шаардлага авсан. Үүнд:

1.Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад Цагдаа, дотоодын цэргийн 53 анги, байгууллага хуульд заасан хугацаанд оруулбал зохих 7897 мэдээллээс 182 мэдээллийг 30 байгууллага хугацаа хоцроож, мэдээлсэн зөрчилд 1 зөвлөмж;

2. Нийслэл, орон нутаг дахь аудитын газраас хийсэн санхүүгийн аудитаар Хангалт үйлчилгээний төв, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газар, Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтэс, Баян-Өлгий, Булган, Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газар, Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс, Сэлэнгэ аймгийн Сайхан, Мандал сум дахь Сум дундын цагдаагийн хэлтэс зэрэг 13 нэгж Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтээр зөрчил, дутагдал заагдаж, нийт 11 зөвлөмж, 2 албан шаардлага авчээ.

Иймд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах, Үндэсний аудитын газраас заагдсан зөрчил, дутагдлыг арилгуулах зорилгоор цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын удирдлагад Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 3а/5082 дугаар албан бичгээр мэдээлэл, 7 заалт бүхий үүрэг, ажлын чиглэл мөн 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 3б/2284 дугаар албан бичгээр Дархан-Уул аймаг дахь цагдаагийн газарт үйл ажиллагаандаа хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөмжийг тус тус хүргэж ажиллаа.

Мөн Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг өөрийн байгууллагын болон www.shilendans.gov.mn гэсэн цахим хуудсанд үнэн зөв, бүрэн мэдээлж, улирлын тайланг хуулийн хугацаанд илгээх талаар болон мэдээлэл байршуулах талаар цахимаар зааварчилгаа өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Тайлант оны эхнээс төсөв хуваарилагдсан Дотоодын цэргийн штабыг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгүүлж, Сангийн яамнаас нэвтрэх нэр, нууц кодыг авч, мэдээлэл байршуулах талаар томилогдсон нягтлан бодогчид зааварчилгаа өгсөн.

Шинэчилсэн Шилэн дансны нэгдсэн систем 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэвтрүүлэхтэй холбогдуулан энэ оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор шинэ системд цагдаа, дотоодын цэргийн 53 /Гэрээт алба нь Санхүү, аж ахуйн албатай байгууллагын регистрын дугаар ижил учраас хамруулаагүй/ анги, байгууллагад бүртгүүлэх ажлын чиглэл хүргэж, 100 хувь хамруулсан.

Тав. Дүгнэлт:

Цагдаа, дотоодын цэргийн 54 анги, байгууллагаас шилэн дансны цахим хуудсанд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 8586 мэдээллийг 100 хувь бүрэн байршуулсан бөгөөд хугацаанд нь 8497, хугацаа хоцорч 89 мэдээлэл байршуулсан нь хугацаа хоцорсон мэдээллийн тоо өмнөх 2020 оноос 2, 2021 оноос 1 дахин буурсан үзүүлэлттэй байгаа нь сайшаалтай байна.

Байгууллагаас энэ чиглэлээр авч хэрэгжүүлсэн зохион байгуулалтын ажил, арга хэмжээ үр дүнгээ өгсөн байна.

Шилэн дансанд мэдээлэл байршуулсан хугацааны хэрэгжилтийг нэгтгэж үзвэл дундаж үзүүлэлтээр **99.0** хувьтай байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хувьд Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллүүд олон нийтэд 100 хувь мэдээлэгдсэн нь төсвийн ил тод байдал хангагдаж, иргэдээс төсвийн хэрэгжилтэд хяналт тавих нөхцөлийг бий болгосон нь уг хуулийн үндсэн зорилтын хэрэгжилт **“МАШ САЙН”** түвшинд байна гэж дүгнэв.

Зургаа. Санал:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна.”-т тусгасан нь ажлын ачаалал нэмэгдүүлэхээр байна.

Иймд зарлагын гүйлгээ хийгдсэн байгууллага бүрд /нэг удаа/ түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргаж байх саналтай байгааг Танд танилцуулж байна.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР